МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ

германы хамтын ажиллагаа
DEUTSCHE ZUSAMMENARBEIT

giz Deutsche Gesellschaft für Internationale Zusammenarbeit (GIZ) GmbH

МЕН
Research & consulting



"МБТС-н байгууллагын гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн тогтолцоог нэвтрүүлэх нь"

Улаанбаатар хот
2023 он

Агуулга

Хураангуй 4

1. Эдийн засгийн өсөлт ба хөдөлмөрийн зах зээл 6

1.1. Эдийн засгийн өсөлт 6

1.2. Хүн ам, ажиллах хүч 7

2. Мэргэжлийн болон техникийн боловсрол сургалт (МБТС)-ын байгууллагын санхүүжилтийн байдлын шинжилгээ 11

2.1. Төрийн өмчийн Мэргэжлийн болон Техникийн боловсролын сургалтын (МБТС)-ын байгууллагуудын санхүүжилтийн байдлын шинжилгээ 11

2.2. Санхүүжилтийн шинэчлэл, эрх зүйн орчны өөрчлөлт 13

3. Гүйцэтгэл, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог нэвтрүүлэх нь 17

3.1. Олон улсын туршлага 17

3.2. МБТС-н санхүүжилтийн томьёо 19

3.3. Санхүүжилтийн томьёоны дагуу хийсэн тооцоолол 19

3.4. Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт 24

4. Санал зөвлөмж 26

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Ажиллагчид салбар, насны бүлгээр 10
Хүснэгт 2. Төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын мэргэжлийн өөрийн өртгийг үндэслэн тогтоосон нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж норматив 14
Хүснэгт 3. Төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын 2024 оны төсвийн тооцоолол 14
Хүснэгт 4. БШУЯ-ны тооцсон нэг суралцагчид ногдох хувьсах зардлын хэмжээ 19
Хүснэгт 5. Сонгогдсон 7 сургуулийн нэг суралцагчид ногдох хувьсах зардал 20
Хүснэгт 6. Салбараар тооцсон итгэлцүүр 21
Хүснэгт 7. Санхүүжилтийн томьёогоор тооцсон МБТС-ын салбарын санхүүжилтийн дүн ..23
Хүснэгт 8. Суралцагчийн тоо болон газарзүйн итгэлцүүр 23

Зургийн жагсаалт

Зураг 1. 1990-2020 оны бодит ДНБ-ний суурь онтой харьцуулсан өсөлт, дахин, 1989=1 6
Зураг 2. 1990-2020 оны ДНБ-ний жил бүрийн өсөлт,бууралтын хувь, зэрэгцүүлэх үнээр 6
Зураг 3. Хүн амын суварга 8
Зураг 4. Ажиллагсад, насны бүлгээр 9
Зураг 5. Ажиллагчид, салбараар 9
Зураг 6. МБТС-н байгууллагын төсөв, суралцагчийн тоо 11
Зураг 7. Суралцагчийн тоо, нэг суралцагчид ногдох хувьсах зардлын харьцаа 12
Зураг 8. Багш албан хаагчийн тоо, суралцагчийн тооны хамаарал 13
Зураг 9. Нөөцийн хуваарилалтын загвар 17
Зураг 10. МБТС-н салбарын төсөв, 2 хувилбарын харьцаа 22

Хураангуй

Монгол улсын эдийн засгийн өсөлт 1990-2006 оны хооронд 1.4 дахин өссөн байхад 2006-2020 онд 2.3 дахин болж өссөн. Мөн хүн ам 2022 оны байдлаар 3458 мянгад хүрч 2000 оныхоос 1.4 дахин өсжээ. Өнгөрсөн 22 жилийн хугацаанд хүн амын насны бүтцэд хөдөлмөрийн насны хүн эзлэх хувь 61 хувь, үүнээс 20-39 насны хүн ам 35 хувь болсон байна. Нийт хүн амын дунд 2000 онд 10-19 насны залуучууд зонхилж байсан бол 2022 онд 30-39 насны хүн амын бүлэг дийлэнх болсон байна. Гэвч Төрийн өмчийн МБТС-н байгууллагын төсөв 2016 онд 45.3 тэрбум төгрөг байсан бол 2022 онд 65.2 тэрбум төгрөг болж 20 орчим тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Харин энэ хугацаанд суралцагчийн 29.3 мянгаас 28.8 мянга болж буурсан байна. Эдийн засгийн тэлэлт, хүн амын дунд эзлэх залуучуудын хувь нэмэгдэж буй энэ орчинд МБТС байгууллагуудын хүчин чадлыг нэмэгдүүлэх, чадавхыг сайжруулах асуудал нэн чухал болж байна. Төрийн өмчийн МБТС-н нэг суралцагчид ногдох хувьсах зардлыг хүүхдийн тоотой харьцуулж судлахад 500 хүртэл суралцагчтай сургуулийн дундаж хувьсах зардал 2.3-5.8 сая төгрөг, 500-1500 суралцагчтай сургуулийнх 1.8-3.3 сая төгрөг, 1500-с дээш суралцагчтай сургуулийнх 1.5-1.8 төгрөг байна. Эндээс харахад суралцагчийн тоо нэмэгдэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардал буурах хандлага ажиглагдаж байна. Өмнөх санхүүжилтийн тогтолцоо нь суралцагчийн тоо, үйл ажиллагааны үр дүнтэй уялдаагүй илүү орцод суурилан явж ирснийг илтгэж байна.

Энэхүү бодлогын судалгааны зорилго нь МБТС-ын байгууллагуудын санхүүжилтийн байдалд үнэлгээ хийж, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн тогтолцоог нэвтрүүлэх санал зөвлөмж боловсруулахад чиглэгдсэн. Судалгааны ажлын дээрх зорилгын хүрээнд дараах ажлуудыг хийсэн.

1. МБТС-н байгууллагуудын нөөцийг хуваарилах, төсвийн төлөвлөлт хийх санхүүгийн томьёо, тооцох арга зүй
2. Сургалтын хөтөлбөрүүдийг Олон улсын стандарт ангилалд суурилан бүлэглэх
3. Оюутны тоо болон газарзүйн итгэлцүүр тооцох
4. Дээрх санхүүжилтийн томьёоны дагуу Төрийн болон хувийн өмчийн МТСБ-ын 2024 оны санхүүгийн тооцоолол, судалгааг хийсэн
5. Мөн туршилтаар сонгосон 7 сургуультай байгуулах үр дүнгийн гэрээний загвар
6. Гүйцэтгэлийн гэрээг дүгнэх шалгуур үзүүлэлтийг тус тус боловсруулсан.

Судалгааны үр дүнтэй уялдан дараах зөвлөмжийг санал болгож байна.

1. Боловсролын тухай хууль болон Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын дээрх заалтуудыг харахад нэлээд Санхүүжүүлэх журмыг Засгийн газрын тогтоолоор, Нэг суралцагчид ногдох мэргэжлийн өөрийн өртөгт суурилсан дундаж норматив зардлыг санхүү, төсвийн болон боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батлахаар заасан байна. Иймд санхүүжүүлэх журам аргачлалаа Засгийн газрын тогтоолоор батлуулах, нэг суралцагчид ногдох хувьсах зардлын хэмжээ, санхүүжилтийн томьёо, газарзүйн болон оюутны тооноос хамаарсан итгэлцүүрээ санхүү, төсвийн болон боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээр батлуулах болж байна. Харин Засгийн газраар батлагдах

санхүүжилтийн журамдаа Санхүүжилтийн томьёогоо оруулж батлуулах нь зүйтэй болов уу.

2. МБТС-ын байгууллагуудын нөөцийн хуваарилалт, санхүүжилтийг дараах томьёо ашиглан тооцох

$$\textbf{Funding} = \sum_{k=0}^{n} \left({}_{k}^{n}\boldsymbol{NS} \times \boldsymbol{Tari} \right) * \boldsymbol{GSK}$$

Funding−Суурь төсөв
NS−Суралцагчийн тоо
Tari-Нэг суралцагчид ногдох хувьсах зардал
GSK-Суралцагчийн тоо болон газарзүйн итгэлцүүр

3. “Түншлэлд суурилсан Техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалт” (ТСТМБС) төсөлд хамрагдаж буй 6 сургууль дээр өртгийн тооцоог үйл ажиллагаатай уялдуулан нарийвчлан тооцох, санхүүжилтийн үндсэн томьёог үр дүнгийн үзүүлэлттэй уялдуулах(санал болгож буй үр дүнгийн гэрээ болон шалгуур үзүүлэлтийн), чадамжийн төвийг бэхжүүлэх зорилгоор гүйцэтгэл суурилан нийт төсвөөр (бүхэл дүнгээр) (90:10) санхүүжилт олгох туршилт хийх.
    a. Барилгын ПК
    b. Монгол-Солонгосын ПК
    c. Техник Технологийн ПК (Хувийн)
    d. Дорнодын ПК
    e. Өмнөговь ПК
    f. Завхан ПК
    g. ТСТМБС


4. Төслөөс боловсруулсан Үйлдэлд суурилсан зардлын тооцооллын EXCEL программыг 2024 онд төрийн өмчийн 37 сургуульд хэрэглэх талаар сургалт явуулах, туршин хэрэгжүүлэх, үр дүнг тооцох, нэгдсэн цахим системтэй холбох арга хэмжээ авах

1. Эдийн засгийн өсөлт ба хөдөлмөрийн зах зээл

1.1. Эдийн засгийн өсөлт


Монгол Улсын эдийн засаг 2020 оны байдлаар 1989 оныхоос бодит үнээр 3.2 дахин өссөн. Энэхүү эдийн засгийн өсөлт, тэлэлт бол шилжилтийн 30 жилд Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжилт хийсний үр дүнг илтгэх чухал үзүүлэлт юм. Эдийн засагт гарсан өөрчлөлт шинэчлэлийг үндсэн хоёр үе шатыг дамжсан гэж үзэж болохоор байна. Тухайлбал, эдийн засгийн өсөлт 1990-2006 оны хооронд 1.4 дахин өссөн байхад 2006-2020 онд 2.3 дахин болж өссөнөөс харахад уул уурхайн салбар өсөлтийг хурдасгахад шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн нь тодорхой харагддаг. Тийм ч учраас эхний 20 жилд манай улсын эдийн засаг үндсэндээ шилжилтийн шатандаа явж ирсэн байхад дараах 10 жилд уул уурхайн салбарын дорвитой өсөлт, үүнээс хамаарсан эдийн засгийн өсөлт гарсан харагддаг.

Зураг 1. 1990-2020 оны бодит ДНБ-ний суурь онтой харьцуулсан өсөлт, дахин, 1989=1



Эх сурвалж: УСХ, Монгол Улсын статистикийн эмхэтгэлүүд

Зураг 2. 1990-2020 оны ДНБ-ний жил бүрийн өсөлт,бууралтын хувь, зэрэгцүүлэх үнээр



Эх сурвалж: УСХ, Монгол Улсын статистикийн эмхэтгэлүүд

Монгол улсын эдийн засаг сүүлийн жилүүдэд хурдацтай өссөн хэдий ч дэлхийн зах зээлийн түүхий эдийн хэлбэлзлээс улам бүр хэт хамааралтай болж, макро эдийн засгийн тогтворгүй **байдалд өртөмтгий хэвээр байна**. **Улмаар түүхий эдийн үнэ болон эдийн засгийн өсөлт, төсвийн алдагдлын хооронд хүчтэй эерэг хамааралтай явсаар ирлээ**.

Эдийн засаг өсөлттэй явж ирсэн ч бас хэлбэлзэл өндөртэй байлаа. 1990-1993 онд буюу төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт хийсэн шилжилтийн эхний 4 жил манай эдийн засаг хүчтэй хямарч, уналт үргэлжилсэн хүнд он жилүүд байсан бол дэлхийн санхүү эдийн засгийн хямралтай холбоотойгоор дараагийн уналт 2009 онд тохиож байсан. Харин, уул уурхайн салбарын огцом сэргэлттэй холбоотойгоор 2010-2012 онуудад эдийн засаг огцом сэргэсэн нь Оюу Толгой болон бусад томоохон төслүүдээр дмжин гадаадын хөрөнгө оруулалт орж ирсэнтэй холбоотой. Гадаадын хөрөнгө оруулалт саарч, гадаад худалдааны нөхцөл байдал муудсантай холбоотойгоор 2015-2017 онуудад манай улсын эдийн засаг зогсонги байдалд орсон. Дараах онуудад уул уурхайн салбарт сэргэлт гарсантай холбоотойгоор эдийн засаг сайжирсан хэдий ч 2020 онд Ковид-19 цар тахал дэлхий нийтийг хамарч манай эдийн засагт дахин нэг томоохон сөрөг шок гарсан.


Ийнхүү Монгол Улсын эдийн засаг, бизнес хүчтэй мөчлөгт өртөмтгий явж иржээ. Энэхүү мөчлөгийг үүсгэдэг хоёр гол салбар нь хөдөө аж ахуй болон уул уурхайн салбарууд юм. Хөдөө аж ахуйн хувьд ган, зуд нүүрлэсэн жилд, тухайлбал, 2000-2001 онд тус салбарын нийт үйлдвэрлэл эрс буурч уналтад орж, нийт эдийн засагт сөргөөр нөлөөлдөг бол уул уурхайн салбарын экспортын бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн үнэ, нийлүүлэлтийн саад бэрхшээлээс үүдэн экспортын орлого огцом буурч, нийт эдийн засагт нөлөө үзүүлдэг.

Монгол улс 2015 онд гэхэд нийт эдийн засагт хувийн секторын эзлэх хувь 80-д хүрч, эдийн засгийн хөгжлийг бүхэлдээ хувийн сектор тодорхойлдог болоод байна. Уул уурхайн салбар өргөжихийн хэрээр хувийн секторын эдийн засагт эзлэх хувь эргээд буурч 74.7 хувь болсон нь Эрдэнэс Таван Толгой, Эрдэнэс Монгол болон бусад төрийн өмчит компаниуд байгуулагдаж, Оюу Толгой зэрэг стратегийн ач холбогдол өндөртэй төслүүдэд төр хувь эзэмших болсонтой холбоотой.

1.2. Хүн ам, ажиллах хүч

Монгол улсын хүн ам 2022 оны байдлаар 3458 мянгад хүрч 2000 оныхоос 1.4 дахин өсжээ. Мөн өнгөрсөн 22 жилийн хугацаанд хүн амын насны бүтцэд хөдөлмөрийн насны хүн эзлэх хувь 61 хувь, үүнээс 20-39 насны хүн ам 35 хувь болсон байна. Доорх хүн амын суваргаас харахад нийт хүн амын дунд 2000 онд 10-19 насны залуучууд зонхилж байсан бол 2022 онд 30-39 насны хүн амын бүлэг дийлэнх болсон байна.

Зураг 3. Хүн амын суварга




Хүн амын насны бүтцийн өөрчлөлттэй уялдан Монгол улсын ажиллах хүчний тоо 1265 мянгад хүрсэн нь 2000 оныхоос 1.4 дахин нэмэгдсэн байна. Хөдөлмөрийн насны хүн амын хөдөлмөрийн зах зээлд дэх оролцоог авч үзэхэд, 1222.9 (57.9%) мянга нь ажиллах хүч, 888.2 (42.1%) мянга нь ажиллах хүчнээс гадуурх хүн ам байна[1].

Ажиллагчдын 95.8 (8.3%) мянга нь 15-24 насныхан (боловсрол, сургалтын дараах хөдөлмөрийн зах зээлд шинээр орж байгаа залуучууд), 942.8 (81.4%) мянга нь 25-54 насныхан (ерөнхий ажиллах хүчний насныхан), 108.3 (9.3%) мянга нь 55-64 насныхан (тэтгэвэрт гарахад ойрхон байгаа) болон 11.4 (1.0%) мянга нь 65 ба түүнээс дээш насныхан байна.


[1] Ажиллах хүчний судалгаа, ҮСХ

Зураг 4. Ажиллагсад, насны бүлгээр



Манай улсын нийт ажиллагчдыг насны бүлгээр авч үзэхэд 2015 онд 15-29 насны ажиллагчдын тоо 267.6 (23.2%) мянга байсан бол 2022 онд уг тоо 226.9 (19.2%) мянга болж 4 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Харин 30-49 насны ажиллагчид 686.5 (59.6%) мянгаас 711.5 (60.3%) мянга болж 0.7 хувиар, 50-аас дээш насны ажиллагчид 197.1 (17.1%) мянгаас 242,1 (20.5%) мянга болж 3.4 хувиар тус тус өссөн байна.

Зураг 5. Ажиллагчид, салбараар



Нийт ажиллагчдын 609.7 (52.6%) мянга нь үйлчилгээний, 290.8 (25.1%) мянга нь хөдөө аж ахуйн салбарт, 257.8 (22.3%) мянга нь үйлдвэрлэлийн салбарт ажиллаж байна.

Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ, Барилга, Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа, Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний чиглэлээр ажиллагчдын тоо 2015 оноос 2-33.5 (0.2-2.9%) мянгаар буурсан бол бусад салбарт 2 - 31.3 (0-2.7%) мянганаар өсөн үзүүлэлттэй байна. Үүнээс боловсруулах үйлдвэрлэлийн салбарын ажиллагчдын тоо (2022 онд 112.6 мянга) хамгийн өндөр өсөлттэй гарсан бол хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилтын салбарт ажиллагчдын тоо (2022 он 293.9мянга) хамгийн их буурсан байна.

Хүснэгт 1. Ажиллагчид салбар, насны бүлгээр

Салбар	15-29 нас		30-аас дээш нас		Өөрчлөлт	
	2015 он	2022 он	2015 он	2022 он	15-29 нас	30-аас дээш нас
Барилга	26,483	15,752	61,636	61,776	(10,731)	140
Боловсрол	14,348	13,727	74,743	90,670	(621)	15,927
Боловсруулах үйлдвэрлэл	17,877	20,990	63,406	91,674	3,113	28,268
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ	32,161	31,933	146,077	114,303	(228)	(31,774)
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	11,868	8,882	25,939	23,137	(2,986)	(2,802)
Мэдээлэл, холбоо	7,524	5,128	8,451	14,029	(2,396)	5,578
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	3,450	2,482	10,656	12,651	(968)	1,995
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	91	815	1,615	1,159	724	(456)
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	9,884	8,678	13,931	13,891	(1,206)	(40)
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	18,541	15,854	49,554	66,275	(2,687)	16,721
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	12,439	8,850	60,240	59,324	(3,589)	(916)
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	3,763	2,220	12,227	11,710	(1,543)	(517)
Урлаг, үзвэр, тоглоом, наадам	2,855	4,507	9,479	9,608	1,652	129
Усан хангамж; бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	828	1,518	5,055	5,317	690	262
Уул уурхай, олборлолт	11,105	10,103	31,536	50,239	(1,002)	18,703
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	6,065	5,935	14,105	28,247	(130)	14,142
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	247	102	719	2,371	(145)	1,652
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт	77,420	56,446	250,140	237,529	(20,974)	(12,611)
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	135	-	814	951	(135)	137
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	6,905	10,615	31,293	39,046	3,710	7,753
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	3,579	2,330	12,038	19,710	(1,249)	7,672
Улсын дүн	**267,568**	**226,867**	**883,654**	**953,617**	**(40,701)**	**69,963**

2022 оны дүнгээр 15-29 насны ажиллагчид 2015 оноос 40.7 мянгаар буурч 30-аас дээш насны ажиллагчид 69.9 мангаар нэмэгдсэн байна. Үүнийг салбараар авч үзвэл 15-29


насны ажиллагчид хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилтын салбарт 7,8 хувиар, барилгын салбарт 4 хувиар тус тус буурсан. Харин 30-аас дээш насны ажиллагчид бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээний салбарт ажиллах нь 3.6 хувь, хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилтын салбарт 1.4 хувиар буурч боловсруулах үйлдвэрлэлд 3.2 хувь, уул уурхай, олборлолт 2.1 хувь, төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалалд 1.9 хувь, боловсролын салбарт 1,8 хувиар тус тус өсжээ.

2. Мэргэжлийн болон техникийн боловсрол сургалт (МБТС)-ын байгууллагын санхүүжилтийн байдлын шинжилгээ

2.1. Төрийн өмчийн Мэргэжлийн болон Техникийн боловсролын сургалтын (МБТС)-ын байгууллагуудын санхүүжилтийн байдлын шинжилгээ

Төрийн өмчийн МБТС-н байгууллагын төсөв 2016 онд 45.3 тэрбум төгрөг байсан бол 2022 онд 65.2 тэрбум төгрөг болж 20 орчим тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Харин энэ хугацаанд суралцагчийн 29.3 мянгаас 28.8 мянга болж буурсан байна.

Зураг 6. МБТС-н байгууллагын төсөв, суралцагчийн тоо




Дээрх зургаас харахад Мэргэжлийн болон Техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын төсвийн төлөвлөлт нь суралцагчийн тоотой шууд хамааралтай бус илүү орцод суурилан санхүүжиж ирснийг илтгэж байна.

Нэг суралцагчид ногдох хувьсах зардал МБТС-ын байгууллагын байршил, төрөл, мэргэжлийн чиглэлээс хамааран ялгаатай байна. Тухайлбал нэг суралцагчид ногдох хувьсах зардал Политехникийн коллежуудад 1.5-3.0 сая төгрөг байхад орон нутгийн МСҮТ-дэд 2.5-5.8 саяын хооронд маш хэлбэлзэлтэй байна. Ялангуяа Сэлэнгэ аймгийн Шаамарын МСҮТ, Булган аймаг дахь ХАА-н МСҮТ, Завхан аймгийн Тосонцэнгэл суман

дахь МСҮТ-н нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын хэмжээ 4.2-5.8 сая төгрөг болж байна. (Зураг-4). Орон нутгийн хөгжлийн бодлогын талаас харгалзаж үзэх асуудлууд байгаа хэдий ч эдийн засгийн үр ашгийг сайжруулах, санхүүгийн менежментийг боловсронгуй болох шаардлагатай харуулж байна. Политехникийн коллежуудын төсөв дунджаар 2-3.5 тэрбум төгрөг, суралцагчийн тоо 1000-2500 орчим, харин орон нутгийн МСҮТ-н төсөв 1-1.8 тэрбум, суралцагчийн тоо 300-800 орчим байна.

Мөн эдгээр сургуулиуд дээр захиргааны ажилчдын тоо багшийн тооноос 20-30 хувиар давсан байна. Ялангуяа Сэлэнгэ аймгийн Шаамар сумын МСҮТ-н Багшийн тоо 12, ЗАА-н тоо 29 байна. Цаашид өртгийн судалгаан дээр суурилан үр ашгийг сайжруулах хэрэгтэйг харуулж байна.


Зураг 7. Суралцагчийн тоо, нэг суралцагчид ногдох хувьсах зардлын харьцаа



Төрийн өмчийн МБТС-н нэг суралцагчид ногдох хувьсах зардлыг хүүхдийн тоотой харьцуулж судлахад 500 хүртэл суралцагчтай сургуулийн дундаж хувьсах зардал 2.3-5.8 сая төгрөг, 500-1500 суралцагчтай сургуулийнх 1.8-3.3 сая төгрөг, 1500-с дээш суралцагчтай сургуулийнх 1.5-1.8 төгрөг байна. Эндээс харахад суралцагчийн тоо нэмэгдэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардал буурах хандлага ажиглагдаж байна.

Орон нутгийн МСҮТ-н хувьд нэг суралцагчид ногдох хувьсах зардал өндөр, суралцагчийн тоотой уялдаагүй орцод суурилан төсөвлөж ирсэн өнөөгийн тогтолцоог зайлшгүй шинэчлэн зохион байгуулах шаардлагатай болж байна. Тухайлбал сургалтын хөтөлбөрийг төрөлжүүлэх, орон нутгийн Жижиг дунд бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаатай уялдуулах, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог нэвтрүүлэх асуудал чухал юм.

Зураг 8. Багш албан хаагчийн тоо, суралцагчийн тооны хамаарал



2.2. Санхүүжилтийн шинэчлэл, эрх зүйн орчны өөрчлөлт

Монгол Улсын Засгийн 2023 оны 10-р сарын 24-ны өдрийн 200-р тогтоолоор “Мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардал, түүний бүрэлдэхүүнийг батлсан.

Энэхүү тогтоолоор

- Төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын мэргэжлийн өөрийн өртгийг үндэслэн тогтоосон нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж норматив
- Төрийн бус өмчийн мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын нэг суралцагчид ногдох хувьсах зардлын хэмжээ
- Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын байршлаас хамаарсан итгэлцүүр
- Мэргэжлийн боловсролын сургалтын хөтөлбөр, мэргэжлийн өөрийн өртгийн итгэлцүүр

Энэхүү Засгийн газрын тогтоол нь зөвлөхүүдийн санал болгосон санхүүжилтийн суурь томьёог ашигласан боловч салбараар ангилсан хувьсах зардлын хэмжээний оронд мэргэжлийн боловсролын сургалтын хөтөлбөр тус бүрээр итгэлцүүр оруулснаараа ялгаатай болсон. Мөн нэг суралцагчид ногдох хувьсах зардлыг дараах байдлаар батлсан.

Хүснэгт 2. Төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын мэргэжлийн өөрийн өртгийг үндэслэн тогтоосон нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж норматив

№	Хөтөлбөрийн агуулга	Өртгийн хэмжээ	Техникийн боловсрол					Мэргэжлийн боловсрол			
			1.5 жил		3 жил			1 жил	2.5 жил		
			1-р курс	2-р курс	1-р курс	2-р курс	3-р курс	1-р курс	1-р курс	2-р курс	3-р курс
1	Бүрэн дунд боловсрол олгох ерөнхий эрдмийн сургалт	2850	992.7	232.8	2280	570	0	0	1425	1425	0
2	Мэргэжлийн боловсрол, сургалтын мэргэжлийн суурь чадамж олгох сургалт	2250	961.9	320.6	1282.5	585	382.5	1125	562.5	438.8	123.8
3	Мэргэжлийн боловсрол, сургалтын мэргэшүүлэх чадамж олгох сургалт	3250	503.1	666.9	0	1105	2145	1722.5	876.9	830.7	600

Засгийн тогтоолын дагуу төрийн өмчийн мэргэжлийн болон техникийн боловсролын сургуулиудын 2024 оны төсвийн тооцоолол хийсэн.

Хүснэгт 3. Төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын 2024 оны төсвийн тооцоолол

Сургалтын байгууллагын нэр	Нийт суралцагчдын тоо	ЗГТ-тооцоолсон нийт төсөв
Архангай аймаг дахь МСҮТ	659	1,615,383
Барилгын политехник коллеж	1721	4,006,513
Баян-Өлгий аймаг дахь МСҮТ	969	2,303,933
Баянхонгор аймгийн политехник коллеж	584	1,353,323
Баянчандмань политехник	504	1,191,842
Булган аймаг дахь МСҮТ	670	1,607,693
Булган аймаг дахь Хөдөө аж ахуйн МСҮТ	210	558,324
Говь-Алтай аймаг дахь МСҮТ	540	1,299,429
Говьсүмбэр аймаг дахь политехник коллеж	503	1,181,730
Дархан Өргөө политехник коллеж	648	1,518,426
Дархан-Уул аймаг дахь политехник коллеж	948	2,210,075
Дархан-Уул аймаг дахь УУЭХ-ний политехник коллеж	431	1,001,483

Дорноговь аймаг дахь политехник коллеж	786	1,818,262
Дорнод аймаг дахь МСҮТ	489	1,152,775
Дорнод аймаг дахь политехник коллеж	703	1,692,934
Дундговь аймаг дахь политехник коллеж	534	1,257,371
Заамар МСҮТ	412	998,650
Завхан аймаг дахь политехник коллеж	560	1,278,817
Зүүнхараа политехник Коллеж	143	332,402
Монгол-Солонгосын политехник коллеж	1070	2,438,908
Налайх дүүрэг дэх политехник коллеж	893	2,082,162
Орхон аймаг дахь ХАА-н МСҮТ	483	1,240,433
Орхон аймгийн мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв	507	1,170,077
Өвөрхангай аймаг дахь политехник коллеж	1481	3,556,008
Өмнөговь аймаг дахь политехник коллеж	820	1,947,843
Сүхбаатар аймаг дахь МСҮТ	580	1,370,347
Сэлэнгэ аймаг дахь МСҮТ	304	725,830
Тосонцэнгэл МСҮТ	270	674,638
Төв аймаг дахь политехник коллеж	165	385,599
Төв аймгийн Эрдэнэ суман дахь МСҮТ	402	957,205
Улаангом политехник коллеж	900	2,132,546
Үйлдвэрлэл Урлалын политехник коллеж	2072	4,885,739
Хөвсгөл аймаг дахь политехник коллеж	662	1,624,762
Хөгжил политехник коллеж	914	2,176,682
Хэнтий аймаг дахь политехник коллеж	526	1,266,228
Хэнтий аймгийн Бор-Өндөр суман дахь МСҮТ	405	956,635
Шаамар МСҮТ	180	451,828
Нийт дүн	**49296**	**116,845,669**

Эх үүсвэр БШУЯ, зөвлөхүүд

Дээрх тооцооллоос харахад мэргэжлийн хөтөлбөр бүрээр итгэлцүүр тогтоох асуудлыг хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэл, хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулсан аргачлал боловсруулж тооцох шаардлагатай нь харагдаж байна. Мөн “Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын мэргэжлийн өөрийн өртгийг үндэслэн тогтоосон нэг сурагчид ногдох хувьсах зардлын төсөв хуваарилах, төсвийн удирдлагыг зохион байгуулах, санхүүжүүлэх аргачлал”-ыг боловсронгуй болгох, суралцагчийн тооноос хамааран цөөн болон олон хүүхэдтэй сургуулиудын төсөв өмнөх жилээс хэт хэлбэлзэлтэй гарах асуудлуудыг анхаарах шаардлагатай байна.

2023 оны 7-р сард Монгол Улсын Их хурлаар “Боловсролын ерөнхий хууль”,”Мэргэжлийн болон техникийн боловсрол,сургалтын тухай” хуулийн шинэчилсэн найруулга батлагдсан. Эдгээр хуулиудын хүрээнд МБТС-н байгууллагуудын санхүүжилттэй холбоотой дараах заалтууд орсон.

Боловсролын тухай хууль

- 38.2.Хувьсах зардлын хэмжээ, бүрэлдэхүүнийг сургуулийн байршил, мэргэжлийн чиглэл, сургалтын хөтөлбөр, суралцагчийн ялгаатай хэрэгцээг харгалзан суралцах тэгш боломж олгох зорилгоор боловсролын сургалтын байгууллагын түвшин бүрээр тогтоож санхүүжүүлэх журмыг Засгийн газар батална.
- 38.3.Энэ хуулийн 38.1.3-т заасан нэмэлт урамшууллын санхүүжилтийг олгоход боловсролын сургалтын байгууллагын гүйцэтгэл, чанар, үр дүнгийн үнэлгээ нь сургалтын чанар, суралцагч бүрийн суралцахуйн үр дүнд гаргасан ахиц, тухайн байгууллагын засаглал, ил тод байдал, хэрэглэгчийн сэтгэл ханамжийн талаар хийсэн хөндлөнгийн үнэлгээнд үндэслэх бөгөөд санхүүжүүлэх журмыг Засгийн газар батална.
- 38.5.2.төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллеж, дотуур байрны багш, ажилтны гүйцэтгэлийн үнэлгээнд суурилсан санхүүжилт;
- 38.5.3.мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн дотуур байрны нийт зардал, төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны хувьсах зардал, хоолны зардал, төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны тогтмол зардал;

МЭРГЭЖЛИЙН БОЛОН ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН ТУХАЙ

- 23 дугаар зүйл.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх
    - 23.1.2.мэргэжлийн өөрийн өртөг тооцох аргачлалыг санхүү, төсвийн болон боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батлах;
    - 23.1.6.мэргэжлийн боловсрол, сургалтын тэргүүлэх болон нэн шаардлагатай мэргэжлийн жагсаалтыг боловсруулж батлуулах;
- 26.1.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын удирдах зөвлөлийн нийтлэг дүрмийг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.
- 28.2.Нэг суралцагчид ногдох мэргэжлийн өөрийн өртөгт суурилсан дундаж норматив зардлыг санхүү, төсвийн болон боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.
- 28.4.Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн тухайн жилийн орлого, зарлагын төсвийн хуваарийг Зөвлөл, боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

Боловсролын тухай хууль болон Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын дээрх заалтуудыг харахад нэлээд Санхүүжүүлэх журмыг Засгийн газрын тогтоолоор, Нэг суралцагчид ногдох мэргэжлийн өөрийн өртөгт суурилсан дундаж норматив зардлыг санхүү, төсвийн болон боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батлахаар заасан байна. Иймд санхүүжүүлэх журам аргачлалаа Засгийн газрын тогтоолоор батлуулах, нэг суралцагчид ногдох хувьсах зардлын хэмжээ, санхүүжилтийн томьёо, газарзүйн болон оюутны тооноос хамаарсан итгэлцүүрээ санхүү, төсвийн болон боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээр батлуулах болж байна. Харин Засгийн газраар батлагдах санхүүжилтийн журамдаа Санхүүжилтийн томьёогоо оруулж батлуулах нь зүйтэй болов уу.

3. Гүйцэтгэл, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог нэвтрүүлэх нь

3.1. Олон улсын туршлага


Олон Улсын хөдөлмөрийн байгууллагын (ОУХБ) мэдээлснээр улс орнууд Мэргэжлийн Боловсролын Сургалтын байгууллагуудын хөгжлийн чиглэл нь хүн амын хэрэгцээнд нийцсэн ажлын байрны холбоотой мэргэжилтнийг бэлтгэх асуудалд илүү анхаарч байна.Үүнд:

- Эмзэг бүлгийн хүн амыг ажлын байртай болгох
- Ажилгүйдлийг бууруулах
- Залуучуудыг (15-24 насны)ажлын байртай болгох

МБТС-ын үйл ажиллагааны гүйцэтгэлийг сайжруулах, сургалтын санал болон хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээний зөрүүг багасгах зорилгоор гарцад (үр дүнд) суурилсан санхүүжилтийн загварыг нэвтрүүлсэн. Эдгээр загварууд нь дараах хэлбэртэй байна.

I. Гүйцэтгэлд суурилсан арга (хөтөлбөрт чиглэсэн) нь, үр дүнд тулгуурлан хөрөнгө оруулалт болон үйл ажиллагааны өртөг дээр суурилан гарцыг төрөөс төсөвлөдөг (дотоод болон гадаад үр ашиг)
II. Гэрээнд суурилсан арга нь сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулж тендер зарлах замаар төсвийг хуваарилдаг
III. Суралцагч-төвтэй санхүүжилт нь суралцагчийн сонголтод суурилан төсөв хуваарилдаг (ваучер, оюутны зээл эсвэл тэтгэлэг хэлбэрээр) төсвийг сургалтын байгууллага сонгон хуваарилдаг.

Зураг 9. Нөөцийн хуваарилалтын загвар



Улс орон бүр өөрийн эдийн засаг, нийгмийн онцлогт суурилан дээрх загваруудыг ялгаатай байдлаар нэвтрүүлж байна. Тухайлбал Тайланд улсын санхүүжилтийн бодлого нь орцод болон гарцад суурилсан холимог загварыг ашиглаж байна. Мөн мэргэжлийн сургалтын хөтөлбөрийн чанарын үнэлгээнд үндэслэн урамшуулал олгодог.

Солонгос улсын хувьд гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн загварыг голчлон хувийн хэвшлийн коллежуудад ашигладаг. 2010-2012 онд дараах гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүдийг нэвтрүүлж эхэлсэн. Дараах шалгуур үзүүлэлтийн үнэлгээг хэрэглэж байсан. Үүнд: төгсөгчдийн ажил эрхлэлтийн хувь-25 хувь, элсэлтийн квот болон хуваарилагдсан суудлын харьцаа-20 хувь, үйлдвэрлэлийн орлого-5 хувь, суралцагчийн төлбөр болон өртгийн харьцаа-5 хувь гэх мэт.

Филиппин улсын хувьд улсын санхүүжилтийн үр ашгийг сайжруулах зорилтын хүрээнд суралцагчид суурилсан санхүүжилтийн загварыг хэрэгжүүлж байна. Нийт сургалтын байгууллагын 90 гаруй хувь нь хувийн хэвшлийнх бөгөөд төрөөс сургалтын хэрэгцээнд суурилан хөтөлбөрөөр дамжуулан санхүүжилт олгодог.

Судлаачид[2] олон улсын түвшинд ашиглагдаж буй чанарыг үнэлэх гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн жагсаалтыг боловсруулсан.

Хэрэгцээнд суурилсан, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст илүү чиглэгдсэн.

Шалгуур	**Түлхүүр асуултууд**	**Үр-дүнд суурилсан аргад төвлөрсөн эсэх**
1. Үр дүнд суурилсан	Шалгуур үзүүлэлт үнэхээр үр дүнд суурилсан уу?	Энэ хэмжиж буй үзүүлэлт нь гарц ба үр дүнд эсвэл орц ба үйл ажиллагаанд чиглэгдэж байгаа эсэх
2. Хяналт	Үр дүнд нөлөөлөх хөндлөнгийн оролцоо байгаа юу?	• Төлөвлөсөн үр дүндээ хүрсэн эсэх • Үр дүн нь хөндлөнгийн оролцооноос хамааралтай эсэх • Оролцогчдыг урамшуулах институт байгаа эсэх
3. Санхүүгийн хөшүүрэг	Төлөвлөсөн үр дүнд хүрэхэд хэр хөшүүрэг болсон?	• Санхүүгийн хувьд “Мөнгөний үнэ цэнэ”, бодлогын хөшүүрэг, эрсдэл болон бусад хүчин зүйлийг тусгасан эсэх
4. Хэмжигдэхүйц байдал	Шалгуур үзүүлэлтүүд цаг хугацааны хувьд тогтвортой, хэмжиж боломжтой эсэх?	• Хөтөлбөрийн зорилт болон шалгуур үзүүлэлтийн уялдаа • Тоон өгөгдлийн чанар болон эх үүсвэр (Захиргааны эсвэл судалгааны мэдээлэл эсэх) • Баталгаажуулалтын арга зам нь хэр зохион байгуулагдсан(бие даасан эсвэл үгүй
5. Хүсээгүй үр дагавар		

[2] S.Holzapfel, H.Janus

3.2. МБТС-н санхүүжилтийн томьёо

Дээрх хуулиудын заалттай уялдан Монгол Улсын Засгийн 2023 оны 10-р сарын 24-ны өдрийн 200-р тогтоолыг шинэчлэх шаардлага үүсэж байна. Энэ хүрээнд дараах зөвлөмжийг санал болгосон.

I. МБТС-ын байгууллагуудын нөөцийн хуваарилалт, санхүүжилтийг дараах томьёо ашиглан тооцох

$$\textbf{Funding} = \sum_{k=0}^{n} \left({}_{k}^{n}\boldsymbol{NS} \times \boldsymbol{Tari} \right) * \boldsymbol{GSK}$$

Funding−Суурь төсөв
NS−Суралцагчийн тоо
Tari-Нэг суралцагчид ногдох хувьсах зардал
GSK-Суралцагчийн тоо болон газарзүйн итгэлцүүр

II. Дээрх томьёоны дагуу тооцоолол хийхэд ангилал ашиглах асуудал нэн чухал. Иймд ISIC буюу Олон улсын эдийн засгийн үйл ажиллагааны стандарт ангиллыг ашиглах. Энэ ангилал нь хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдуулан санхүүжилтийн бодлогоо зохицуулах давуу боломжтой. Мөн зорилгоос хамаарч ISCED буюу Олон улсын боловсролын стандарт ангилалтай зэрэгцүүлэн ашиглах боломжтой. Мэргэжлийн хөтөлбөрөөр ангилсан.
III. Оюутны тоо болон байршлын итгэлцүүрийг оруулсан нь орон нутгийн онцлогийг харгалзан санхүүжүүлэх боломжийг бүрдүүлсэн.
IV. Мэргэжлийн болон техникийн боловсролын нэг суралцагчид ногдох хувьсах зардлыг ялгаатай тооцсон.

3.3. Санхүүжилтийн томьёоны дагуу хийсэн тооцоолол

Санхүүжилтийн томьёоны дагуу хоёр хувилбараар тооцооллыг хийлээ. Үүнд

- Засгийн газрын 200-р тогтоолын тоо мэдээлэл дээр үндэслэсэн тооцоолол, төсвийн төлөвлөлт
- Засгийн газрын тоо мэдээлэл, нэг оюутны хувьсах зардлын хэмжээг шинэчилсэн тооцоолол, төсвийн төлөвлөлтийн загвар

Энэхүү тооцооллыг хийхийн зэрэгцээ төсвийн төлөвлөлт хийх загварыг боловсруулсан.

Санхүүжилтийн томьёоны суурь үзүүлэлт Нэг суралцагчид ногдох хувьсах зардлын хэмжээг БШУЯ-ны тооцоолол болон “Эм Эм Си Жи” зөвлөх компанийн сонгогдсон сургуулиудын өртгийн судалгаатай харьцуулж тооцоонд ашигласан.

Хүснэгт 4. БШУЯ-ны тооцсон нэг суралцагчид ногдох хувьсах зардлын хэмжээ

№	Зардлын төрөл/ Боловсролын түвшин	Техникийн боловсрол					Мэргэжлийн боловсрол			
		1.5 жил		3 жил			1 жил	3 жил		
		1-р курс	2-р курс	1-р курс	2-р курс	3-р курс	1-р курс	1-р курс	2-р курс	3-р курс
1	Хувьсах зардлын хэмжээ	2457.7	1220.3	3562.5	2260	2527.5	2847.5	2685.5	2777	2887.5

Эх үүсвэр: БШУЯ

БШУЯ Нэг суралцагчид ногдох хувьсах зардлыг техникийн болон мэргэжлийн сургалт, дотроо суралцах жилийн онцлогийг тусгаж тооцсон. Энэхүү тооцоогоор нэг суралцагчид ногдох хувьсах зардал техникийн боловсролынх 2405 мянга төгрөг, мэргэжлийн боловсролынх 2800 мянган төгрөг байна.

Хүснэгт 5. Сонгогдсон 7 сургуулийн нэг суралцагчид ногдох хувьсах зардал

Сонгогдсон 7 МБСБ	Мэргэжлийн боловсрол		Техникийн боловсрол	
	1	2.5	1.5	3
Барилгын ПТК	4,397.90	3,281.90	4,311.80	-
Дархан-Уул аймаг дахь УУЭХ-ний ПТК	2,159.50	1,756.10	1,917.90	2,384.70
Дорнод аймаг дахь ПТК	3,942.50	2,575.70	2,852.60	2,752.50
Завхан аймаг дахь ПТК	3,530.90	3,225.80	3,444.00	2,960.20
Монгол-Солонгосын ПТК	-	1,968.20	2,716.60	2,815.50
Өмнөговь аймаг дахь ПТК	3,566.70	3,139.80	3,153.60	3,098.20
Техник технологийн ПТК	2,502.30	1,928.50	2,153.90	2,534.30
Нийт дундаж нэг суралцагчид ногдох хувьсах зардал, нэг жилд	**2,907.00**	**2,609.20**	**2,720.70**	**2,625.70**

Эх үүсвэр: Эм Эм Си Жи ХХК

Тус компанийн зөвлөхүүдийн тооцооллоор нэг суралцагчид ногдох жилийн дундаж хувьсах зардлын хэмжээ техникийн боловсролынх 2673 мянган төгрөг, мэргэжлийн боловсролынх 2758 мянган төгрөг гарсан нь ойролцоо дүнтэй байна.

Энэхүү тооцоолол дээр суурилан нэг суралцагчид ногдох хувьсах зардлын хэмжээг санхүүжилтийн томьёоны суурь аргачлалын дагуу салбарын ангиллаар тооцлоо. Олон улсын эдийн засгийн үйл ажиллагааны стандарт ангилал(ISIC)-ын аргачлалын дагуу мэргэжлийн сургалтын хөтөлбөр бүрээр бүлэглэж нийт 17 салбараар дундаж өртөг тооцсон. Мэргэжлийн болон техникийн боловсролоор ялгаж ангилан тус тусд нь нэг суралцагчид ногдох хувьсах зардлыг тооцсон.


Хүснэгт 6. Салбараар тооцсон итгэлцүүр

№	Салбар	Мэргэжлийн боловсрол		Техникийн боловсрол	
		Нэг суралцагчид ноогдох хувьсах зардал	Хувийн жин	Нэг суралцагчид ноогдох хувьсах зардал	Хувийн жин
1	Аялал жуулчлал	2,794	1.01		
2	Барилга, зам	2,788	1.00	1,989	1.10
3	Боловсруулах үйлдвэрлэл	2,798	1.01	2,206	1.22
4	Бусад	2,801	1.01	2,278	1.26
5	Зочид буудал, нийтийн хоол	2,799	1.01		
6	Мэдээлэл, холбоо	2,783	1.00	2,247	1.24
7	Мэргэжлийн болон техникийн үйл ажиллагаа	2,806	1.01	2,147	1.19
8	Соёл урлаг	2,780	1.00	1,927	1.07
9	Тээвэр	2,796	1.01	1,962	1.08
10	Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх	2,792	1.00	2,335	1.29
11	Уул уурхай	2,807	1.01	2,488	1.37
12	Үйлчилгээ	2,794	1.01	1,810	1.00
13	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй	2,805	1.01	2,575	1.42
14	Эрчим хүч,дулаан	2,800	1.01	2,160	1.19

Энэхүү санхүүжилтийн томьёоны суурь нь нэг суралцагчид ногдох хувьсах зардлын хэмжээг салбарын ангилалд суурилан тооцох явдал юм. Ингэснээр ойролцоо сургалтын хөтөлбөрүүдийг нэгтгэж нэг ангилалд оруулах, хөгжлийн бодлоготой уялдан тэргүүлэх чиглэлүүдийг салбарын хувийн жин ашиглан дэмжих, сургуулийн төрөлжилтийг хөгжүүлэх хөшүүрэг болно. Бодлого боловсруулагчдын зүгээс энэхүү салбарын хувийн жинг өөрчлөх замаар тэргүүлэх чиглэлийг дэмжих боломжтойгоор төлөвлөлтийн загвар, тооцооллыг хийсэн.

МБТС-н салбарын төсвийг Засгийн газрын 200-р тогтоолын хүрээнд болон дээрх нэг суралцагчид ногдох хувьсах зардалд суурилан хоёр хувилбараар тооцоолол хийлээ.

Зураг 10. МБТС-н салбарын төсөв, 2 хувилбарын харьцаа



Засгийн газрын 200-р тогтоолыг шинэчлэх ажлын хүрээнд санал болгосон санхүүжилтийн томьёоны дагуу МБТС-ын салбарын 2024 оны төсөв 81.3 тэрбум төгрөг болохоор байна.

Хүснэгт 7. Санхүүжилтийн томьёогоор тооцсон МБТС-ын салбарын санхүүжилтийн дүн

№	Салбар	Нийт суралцагчдын тоо	Салбарын санхүүжилт (Хуучин дүнгээр)	Салбарын санхүүжилт (Шинэ дүнгээр)
1	Аялал жуулчлал	296	841,076	843,507
2	Барилга, зам	9802	22,619,007	26,843,490
3	Боловсруулах үйлдвэрлэл	3801	8,921,995	10,373,152
4	Бусад	289	743,789	753,466
5	Зочид буудал, нийтийн хоол	1736	4,012,673	4,955,803
6	Мэдээлэл, холбоо	1542	3,593,819	4,191,895
7	Мэргэжлийн болон техникийн үйл ажиллагаа	1169	2,640,655	3,162,481
8	Соёл урлаг	584	1,376,344	1,625,295
9	Тээвэр	2839	6,292,972	7,823,337
10	Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх	675	1,667,723	1,759,482
11	Уул уурхай	1688	4,156,185	4,660,791
12	Үйлчилгээ	1493	3,572,151	4,148,848
13	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй	2408	6,603,725	6,777,421
14	Эрчим хүч,дулаан	1372	3,010,018	3,470,715
	Нийт санхүүжилт	**29694**	**70,052,131**	**81,389,681**

Түүнчлэн санхүүжилтийн томьёонд суралцагчийн тооны болон газарзүйн итгэлцүүрийг дараа байдлаар тооцсон. Мөн яамны бодлогын түвшинд эдгээр итгэлцүүрийн хэмжээг өөрчлөх боломжтойгоор төсвийн тооцооллын загварт тусгасан.

Хүснэгт 8. Суралцагчийн тоо болон газарзүйн итгэлцүүр

Байршил	Ангилал	Дундаж хувийн жин	Суралцагчийн тооны итгэлцүүр ()	Газар зүй итгэлцүүр	Сурагчийн тоо, байршлаас хамаарсан итгэлцүүр
Нийслэлд	801-1200	1.27	1.00	1.00	1.00
	1200-с дээш	1.22	1.00	1.00	1.00
Аймгийн төвд	400-с доош	1.42	1.70	1.35	1.63
	400-800	1.40	1.50	1.35	1.47
	801-1200	1.37	1.10	1.35	1.15
	1200-с дээш	1.47	1.00	1.35	1.07
Сумын төвд	400-с доош	1.39	1.80	1.70	1.78
	400-800	1.49	1.90	1.70	1.86

Энэхүү итгэлцүүрийг ашигласнаар орон нутгийн онцлог, суралцагчийн тооны хэт хэлбэлзлийг зохицуулах боломжтой.

3.4. Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт

ТБМС-н гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн тогтолцоог хэрэгжүүлэхэд гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүд маш чухал үүрэгтэй. Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг илүү гарц болон үр ашигтай уялдуулан тогтоож, суурь түвшнийг зөв тооцох, түүнийгээ хянах цахим тогтолцоо бүрдүүлэх нь гүйцэтгэлийн санхүүжилтийн чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Энэхүү хяналтын тогтолцоог олон улсын жишигт суурилсан ABC буюу Үйлдэлд суурилсан зардлын тооцоололд суурилж хэрэгжүүлэх боломжтой юм. GIZ-н гадаад болон дотоодын зөвлөхүүдийн зүгээс энэ чиглэлээр нэлээд санал,зөвлөмж, тооцооллыг хийгээд байна.

Энэ хүрээнд дараах гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүдийг санал болгож байна.
Санхүүгийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт

Үр ашгийн үзүүлэлт	Scope	Зорилтод/Жишиг үзүүлэлт	Эх сурвалж
Нэг суралцагчид ногдох өртөг=Нийт өртөг /мэргэжлийн хөтөлбөрт ногдох оюутны тоо	Мэргэжлийн хөтөлбөр	Батлагдсан хувьсах зардлын хэмжээ	1-БШУЯ (2-Олон улсын түвшин?)
Үр дүнгийн үзүүлэлт			
Төгсөгчдийн ажил эрхлэлтийн хувь		Улсын дундаж	Судалгаа
Ажиллагсдын харьцааны үзүүлэлт			
Нийт ажилчдад ногдох мэргэжлийн багш %	Сургууль	ТБМБ-н байгууллагын дундаж	1-БШУЯ 2-Олон улсын үзүүлэлтүүд
Нийт ажилчдад ногдох ерөнхий эрдмийн багш %			
Нийт ажилчдад ногдох удирдлага болон захиргааны ажилтан %			
Нийт ажилчдад ногдох сургалт, арга зүйн туслах ажилтан %			
Нийт ажилчдад ногдох үйлчилгээний ажилтан %			
Оюутны үзүүлэлт			
Нэг багшид ногдох оюутны тоо (бүгд)		Нэг мэргэжлийн хөтөлбөрт ногдох улсын дундаж	1-БШУЯ 2-Олон улсын үзүүлэлтүүд
Мэргэжлийн багшид ногдох оюутны тоо		Мэргэжлийн хөтөлбөрөөр	

Нэг мэргэжлийн чиглэлд ногдох дундаж оюутны тоо			
Хамгийн олон оюутантай мэргэжлийн хөтөлбөр			
Хамгийн олон оюутантай салбарын нэг багшид ногдох оюутны тоо			
Нийт суралцагчдад эмэгтэй оюутны эзлэх хувь			
Төсвийн үзүүлэлтүүд			
%-Нийт төсөв эзлэх Мэргэжлийн боловсролын зардал	Төсөвт эзлэх хувь-%	Нийт МБТС-ын байгууллагуудын дундаж	1-БШУЯ 2-Олон улсын үзүүлэлтүүд
%-Нийт төсөвт эзлэх ерөнхий боловсролын зардал			
%-Төсөвт эзлэх Багшийн үндсэн цалин, НДШ			
%-Төсөвт эзлэх багшийн нэмэгдэл хөлс, НДШ			
%-Төсөвт эзлэх сургалтын хэрэглэгдэхүүний зардал			
%-Төсөвт эзлэх менежментийн зардал			
Орлого эх үүсвэр			
%-төсвийн санхүүжилт	Нийт МБТС-байгууллагын нийт орлогод өөрийн орлогын эзлэх хувь-%	Нийт МБТС-ын байгууллагуудын дундаж	1-БШУЯ
%-бизнесийн үйл ажиллагааны орлого			
% -Оюутны төлбөр			

Эх үүсвэр: Зөвлөх Андрегийн санал дээр өөрийн саналуудыг нэмж оруулаа.

Энэхүү гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн тогтолцоог амжилттай хэрэгжүүлэхэд санхүүжилтийн томьёо чухал үүрэгтэй бөгөөд дараах хүчин зүйлийг анхаарах хэрэгтэй байдаг.

- Стандартад суурилсан чанарын баталгаажуулалт, түүнийг хэмжих, хянах хэрэгсэл болон чадавхыг бүрдүүлэх шаардлагатай
- МБТС-н байгууллагыг институтийн хувьд бие даасан удирдлагын тогтолцоог бүрдүүлэх
- Төгсөгчдийн ажил эрхлэлтийн байдал, төгсөлтийн хувь хэмжээ, сургалтын өртөг зэргийг агуулсан мэдээллийн тогтолцоо
- МБТС-ын байгууллагуудын удирдах ажилтны мэргэжлийн хөгжлийг дэмжих арга хэрэгслүүдийг нэвтрүүлэх

Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн тогтолцоог нэвтрүүлэхэд дээрх гарцад чиглэсэн шалгуур үзүүлэлтээ зөв тогтоох, шалгуур үзүүлэлтээ хянах мэдээллийн тогтолцоо маш чухал үүрэгтэй.

4. Санал зөвлөмж

Боловсролын тухай хууль болон Мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтын тухай хууль шинэчилсэн найруулгаар батлагдсантай уялдаж Засгийн газрын 2023 оны 10-р сарын 24-ны өдрийн 200-р тогтоолыг шинэчлэх шаардлага үүсэж байна. Энэхүү тогтоолоор “Мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардал, түүний бүрэлдэхүүнийг баталсан.

ЗӨВЛӨМЖ

5. Боловсролын тухай хууль болон Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын дээрх заалтуудыг харахад нэлээд Санхүүжүүлэх журмыг Засгийн газрын тогтоолоор, Нэг суралцагчид ногдох мэргэжлийн өөрийн өртөгт суурилсан дундаж норматив зардлыг санхүү, төсвийн болон боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батлахаар заасан байна. Иймд санхүүжүүлэх журам аргачлалаа Засгийн газрын тогтоолоор батлуулах, нэг суралцагчид ногдох хувьсах зардлын хэмжээ, санхүүжилтийн томьёо, газарзүйн болон оюутны тооноос хамаарсан итгэлцүүрээ санхүү, төсвийн болон боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээр батлуулах болж байна. Харин Засгийн газраар батлагдах санхүүжилтийн журамдаа Санхүүжилтийн томьёогоо оруулж батлуулах нь зүйтэй болов уу.

6. МБТС-ын байгууллагуудын нөөцийн хуваарилалт, санхүүжилтийг дараах томьёо ашиглан тооцох

$$\textbf{Funding} = \sum_{k=0}^{n} \left({}_{k}^{n}\boldsymbol{NS} \times \boldsymbol{Tari} \right) * \boldsymbol{GSK}$$

Funding−Суурь төсөв
NS−Суралцагчийн тоо
Tari-Нэг суралцагчид ногдох хувьсах зардал
GSK-Суралцагчийн тоо болон газарзүйн итгэлцүүр

7. “Түншлэлд суурилсан Техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалт” (ТСТМБС) төсөлд хамрагдаж буй 6 сургууль дээр өртгийн тооцоог үйл ажиллагаатай уялдуулан нарийвчлан тооцох, санхүүжилтийн үндсэн томьёог үр дүнгийн үзүүлэлттэй уялдуулах(санал болгож буй үр дүнгийн гэрээ болон

шалгуур үзүүлэлтийн), чадамжийн төвийг бэхжүүлэх зорилгоор гүйцэтгэл суурилан нийт төсвөөр (бүхэл дүнгээр) (90:10) санхүүжилт олгох туршилт хийх.

I. Барилгын ПК
II. Монгол-Солонгосын ПК
III. Техник Технологийн ПК (Хувийн)
IV. Дорнодын ПК
V. Өмнөговь ПК
VI. Завхан ПК
VII. ТСТМБС

8. Төслөөс боловсруулсан Үйлдэлд суурилсан зардлын тооцооллын EXCEL программыг 2024 онд төрийн өмчийн 37 сургуульд хэрэглэх талаар сургалт явуулах, туршин хэрэгжүүлэх, үр дүнг тооцох, нэгдсэн цахим системтэй холбох арга хэмжээ авах